

## АВТО ЗОГСООЛЫН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20.....

№ .....

Улаанбаатар хот

Нэг талаас: ..... /цаашид “Худалдагч” гэх/,

нөгөө талаас: ..... /цаашид “Худалдан авагч”, хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын “Иргэний хууль”-ийн 243-261 дүгээр зүйлд заасныг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, энэхүү “Худалдах, худалдан авах гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.

### Нэг. Гэрээний зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр *Сүхбаатар дүүрэг, .... хороо, ... байрны В1 давхарын .... тоот .....* мкв хэмжээтэй авто машины зогсоолын зориулалт бүхий ... мкв талбай /цаашид “авто зогсоол” гэх/-г Худалдан авагчийн өмчлөлд тогтоосон хугацаанд шилжүүлэх, Худалдан авагч нь тохирсон үнийг гэрээнд заасан хуваарийн дагуу Худалдагчид төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 .....
- 1.3 Энэхүү гэрээнд хэрэглэгдэж буй дараах нэр томъёог дор дурьдсанаар ойлгоно. Үүнд:
  - 1.3.1 “Биет байдлын доголдолгүй байх” гэдэгт худалдаж буй авто зогсоол нь гэрээгээр тогтоосон хэмжээ, зориулалтын дагуу ашиглах боломжтой байхыг;
  - 1.3.2 “Эрхийн зөрчилгүй байх” гэдэгт үл хөдлөх хөрөнгийн хувьд аливаа гуравдагч этгээд өөрийн эдлэх эрхийн талаар Худалдагчид гомдлын шаардлага гаргахааргүй байхыг;

### Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 2.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээний хугацааг сунгаж болно.

### Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэхүү гэрээний дагуу худалдан борлуулж буй авто зогсоолын нийт үнэ ..... /үсгээр / төгрөг байхаар талууд харилцан тохиролцов.
- 3.2 Худалдан авагч нь гэрээний 3.1-т заасан үл хөдлөх хөрөнгийн үнийг \_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ -ний өдөр худалдагч талын ..... тоот дансанд төлнө.
- 3.3 Худалдагч нь гэрээний 3.1-т заасан төлбөрийг бүрэн хүлээн авснаас хойш хуанлийн 7 хоногийн дотор авто зогсоолын өмчлөх эрхийн гэрчилгээг Худалдан авагчийн нэр дээр шилжүүлж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгийг худалдан авагчид гаргаж өгнө.

### Дөрөв. Авто зогсоол хүлээлцэх

- 4.1 Худалдагч нь гэрээний 3.1-т заасан төлбөрийг хүлээн авснаас хойш хуанлийн 3 хоногийн дотор авто зогсоолыг Худалдан авагчийн эзэмшил, ашиглалтад хүлээлгэн өгнө.

*Үргэлжлэл бий .... /4х/*